



*МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГУУР, ХӨГЖЛИЙН  
ЗУТГУУР*





## БИДНИЙ ТУХАЙ

Төмөр замын ачаа тээвэр

- ▶ Ачаа тээвэрлэлт
- ▶ Тээвэр зуучлал
- ▶ Шилжүүлэн ачих терминал
- ▶ Чингэлэг тээврийн авто терминал

Хөдлөх бүрэлдэхүүний засвар, үйлчилгээ

- ▶ Зүтгүүрийн депо
- ▶ Вагон засварын депо

Төмөр замын суурь бүтэц

- ▶ Зам төмрийн сэв шалгагч вагон
- ▶ Зам оношилгооны вагон – лаборатори

Төслүүд

- ▶ Хэрэгжүүлэн ажилласан төслүүд
- ▶ Хэрэгжүүлж буй төслүүд

Захиалагчийн хяналт

Төмөр замын зураг төсөл

## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



“Тавантолгой төмөр зам” ХХК нь 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдөр үүсгэн байгуулагдаж төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, тээвэрлэх хөдлөх бүрэлдэхүүн засварлах зэрэг чиглэлээр цогц үйл ажиллагаа явуулж Монгол Улсын төмөр замын мэргэшсэн инженерингийн компани юм.

Бид төмөр замын үйл ажиллагаа, төслийн удирдлагыг үндэсний эрх ашигт нийцсэн, аюулгүй байдлыг эрхэмлэсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартаар хэрэгжүүлдэг.

“Тавантолгой төмөр зам” ХХК нь өөрсдийн бий болгосон туршлага, мэргэшсэн баг хамт олон, үйл ажиллагааны давуу тал, хуримтлуулсан туршлагаадаа тулгуурлан дотоодын төдийгүй олон улсын түвшинд “Төмөр замын ашиглалт, тээвэрлэлтийн цогц үйлчилгээ” үзүүлэгч үндэсний шилдэг аж ахуйн нэгж болохоор зорин ажиллаж байна.

## ОЛОН УЛСЫН СТАНДАРТ НЭВТРҮҮЛЖ БАЙНА

Богино хугацаанд компанийн засаглалыг бэхжүүлэн, үйл ажиллагаагаа дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын стандартуудыг нэгэн зэрэг нутагшуулж эхлээд байна.



Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001



Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001



ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо ISO 45001



Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 27001



Төслийн менежментийн арга зүй ISO 21500


# ТӨМӨР ЗАМЫН АЧАА ТЭЭВЭР

## Төмөр замын бүх төрлийн ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ

Манай компани нь дараах чиглэлд ачаа тээвэрлэлтийн үйлчилгээг 24 цагийн турш тасралтгүй зохион байгуулж байна.

- ▶ Тавантолгой - Гашуунсухайт
- ▶ Тавантолгой - Цогтцэций - Зүүнбаян
- ▶ Тавантолгой - Цогтцэций - Ханги
- ▶ Гашуунсухайт - Тавантолгой
- ▶ Гашуунсухайт - Тавантолгой - Цогтцэций - Зүүнбаян
- ▶ Гашуунсухайт - Тавантолгой - Цогтцэций - Ханги

## ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЕИЙН АЧААНЫ ТОО ХЭМЖЭЭ



Эх сурвалж: "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн ТҮЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 03 дугаар тогтоолоор батлагдсан "Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр-2050"



## ТАВАНТОЛГОЙ ӨРТӨӨ

Бүх төрлийн ачааны ажиллагаанд нээлттэй, 24 цагийн үйл ажиллагаатай, ангигүй зэрэглэлийн өртөө юм. Тус өртөө нь 1317-2587 метр хүртэл ашигтай урттай хүлээн авч, явуулах 12 замтай ба бүрэн хүчин чадлаараа ажиллахад хоногт 1400 вагон, 90000 тонн ачаа боловсруулах чадвартай. Тус өртөө нь DJU маркийн динамик 1 ширхэг, SC-150 маркийн статик 1 ширхэг, нийт 2 вагон пүүтэй, Сэлгээний 1 илчит тэрэгтэйгээр 3 салбар замд үйлчилж, хоногт 156 вагон, 10000 тонн ачаа боловсруулж байна.



## ГАШУУНСУХАЙТ ӨРТӨӨ

---

Бүх төрлийн ачааны ажиллагаанд нээлттэй (нурмаг ачаанаас бусад), 24 цагийн үйл ажиллагаатай, ангигүй зэрэглэлийн, хилийн өртөө юм. Тус өртөө нь 1659-2486 метр хүртэл ашигтай урттай хүлээн авч, явуулах 7 замтай ба бүрэн хүчин чадлаараа ажиллахад хоногт 1000 вагон, 64000 тонн ачаа боловсруулах чадвартай.



## ГАШУУНСУХАЙТ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ТЕРМИНАЛ

---

Гашуунсухайт хилийн өртөөг түшиглэн нийт 30 га талбайд байгуулагдсан ба бүрэн ашиглалтад орсноор жилд 24.9 сая.тн ачаа боловсруулах хүчин чадалтай юм. Тус терминал нь төмөр зам болон авто тээврийн терминалын гэсэн 2 хэсэгт бүх төрлийн ачааг ачих, буулгах, хадгалах, жинлэх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

## ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН АВТО ТЕРМИНАЛ

---

Төмөр замын терминалын хэсэгт: Хоногт 600 чингэлэг, 19.5 мян.тн ачаа боловсруулж, 2100 TEU чингэлэг хадгалах хүчин чадалтай.

Автын терминалын хэсэгт: Хоногт 400 чингэлэг, 14 мян.тн ачаа боловсруулж, 800 TEU чингэлэг хадгалах хүчин чадалтай.





## ТӨМӨР ЗАМЫН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ, ЛОГИСТИК

Төмөр замын болон холимог тээврийн “Тээвэр зуучлал”-ын үйлчилгээ:


- ▶ Олон Улсын ачаа тээврийн зуучлал
- ▶ Дотоодын төмөр замын болон холимог тээврийн зуучлал
- ▶ Төслийн ачааны тусгай тээвэрлэлт

Төмөр замын бүх төрлийн ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ:

- ▶ Төмөр замын “Суурь бүтэц ашиглуулах” үйлчилгээ
- ▶ Аюултай ачааны тээвэрлэлт
- ▶ Уул уурхайн бүтээгдэхүүний холимог тээвэрлэлт
- ▶ Бүх төрлийн чингэлэг тээвэрлэлт
- ▶ Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээрх хүнд жинтэй, хэтрүү овортой ачааны тээвэрлэлт

Терминал, логистикийн үйлчилгээ:

- ▶ Бүх төрлийн ачааг нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шилжүүлэн ачих буулгах, бэхлэх үйлчилгээ
- ▶ Тавантолгой, Гашуунсухайт өртөөдөд бүх төрлийн чингэлэг болон машин механизм, тоног төхөөрөмжийн хадгалалт
- ▶ Тээвэрлэлттэй холбоотой бүх төрлийн бичиг баримт боловсруулалт
- ▶ Гаалийн бүрдүүлэлт, ачааны мэдүүлэг бичилтийн үйлчилгээ
- ▶ Бүх төрлийн тээврийн хэрэгслээс чингэлэг болон бүх төрлийн ачааг шилжүүлэн ачих







## ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЗАВСАР ҮЙЛЧИЛГЭЭ

### ЗҮТГҮҮР

Тавантолгой - Гашуунсухайт чиглэлийн төмөр замд АНУ-ын "Progress Rail A Caterpillar" компанийн гол замын SD70Ac/LW серийн 16 зүтгүүр, "National Railway Equipment" компанийн сэлгээний 2GS16C серийн 1 зүтгүүрээр тээвэрлэлтийг хийж гүйцэтгэнэ. SD70Ac/LW серийн зүтгүүрийн техникийн үзүүлэлт:

- ▶ 5000 тонн жинтэй галт тэргийг татах
- ▶ 4500 морины хүч буюу 3355 кВт чадал
- ▶ Хувьсахаас хувьсах гүйдлийн AC-DC-AC цахилгаан дамжуулгын систем
- ▶ Хөдөлгүүрийн цахилгаан форсунк
- ▶ НТСР загварын радиаль тэргэнцэр
- ▶ Олон улсын хүрээлэн буй орчны EU Stage IIIA түвшний шаардлагыг хангасан
- ▶ Ашиглалтын үеийн зардлын хялбар засвар үйлчилгээ
- ▶ Өндөр найдвартай бүтээцээр оновчтой шийдсэн

### ЗҮТГҮҮРИЙН ДЕПО

Зүтгүүрийн депо нь Америк зүтгүүрт техник үйлчилгээ, урсгал засвар болон их засварыг хийх зориулалтаар барьж байгуулсан анхны депо бөгөөд үндсэн гурван бүрдэл хэсэгтэй.

1. Хоёр зам бүхий зэхэлтийн хэсэг
2. Нэг үзлэгийн суваг бүхий бага засварын цех
3. Хоёр үзлэгийн суваг бүхий их засварын цех

Зүтгүүрийн депо ба зэхэлтийн байгууламж нь дараах технологийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.

- ▶ Их засварын 45 тонны гүүрэн кран
- ▶ Бага засварын 10 тонны гүүрэн кран
- ▶ Хос дугуй зорох машин нь сүүлийн үеийн Герман улсын технологийн СНС удирдлагатай бүрэн автомат суурь машин
- ▶ Хос дугуйн моторын блок солих машин нь сүүлийн үеийн технологиор хийгдсэн СНС удирдлагатай бүрэн автомат машин
- ▶ 40 тонны 4 домкрат суурилуулгдсан
- ▶ Герман улсын механик багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон
- ▶ Зүтгүүрийг галт тэрэгнээс салгалгүйгээр өртөөний зам дээр сүүлийн үеийн технологиор хийгдсэн тоног төхөөрөмж хэрэгслээр зэхэх
- ▶ Элс бэлтгэх, түгээх, хадгалах инженерийн байгууламжийн тоног төхөөрөмж нь бүрэн автомат ажиллагаатай

## ВАГОН

Төмөр замын ачаа тээвэрлэлт хийх 12-9853 төрлийн ачааны хагас вагон 400 ширхэг, 13-6724 төрлийн тавцант вагон 390 ширхэг, 11-6874 төрлийн битүү вагон 8 ширхэг, 13-6851-04 төрлийн хашлагатай тавцант вагон 13 ширхэг зэрэг ачааны нийт дөрвөн төрлийн 811 вагоныг ОХУ-ын Тихвины вагоны үйлдвэрээс, 1 ширхэг GСУ 300 моторт зорчигчийн вагоныг БНХАУ-аас Монгол Улсын хилээр тус тус хүлээн авч дууссан.



## ВАГОН ЗАСВАРЫН ДЕПО

Вагон засварын депо нь Монгол улсдаа хамгийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, 6 үндсэн цех, 4 тасагтай засварын 2 зам, 6 комплект домкрат 104 төрлийн хагас болон бүрэн автомажсан тоног төхөөрөмж, гар багаж, төхөөрөмжтэй. 1500 гаруй ачааны вагонд дунд ба их засвар хийх хүчин чадалтай.

### Вагон депо бүрдэл:

- ▶ Задалж угсрах засварын цех
- ▶ Тэргэнцэр засварын цех
- ▶ Хос дугуй засварын цех
- ▶ Авто тоормосны тасаг
- ▶ Авто угсраа, шингээх аппарат засварын тасаг
- ▶ Механик тоноглолын цех
- ▶ Үл эвдэх сорилтын тасаг
- ▶ Нээлхий засварын тасаг
- ▶ Хажуу арал, дам нуруу засварын тасаг
- ▶ Тоормосны триангель засварын тасаг





Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замын дээд бүтэц, дохиолол, холбоо, эрчим хүчний чиглэлээр Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажилладаг.

Манай компани нь төмөр замын суурь бүтцийн чиглэлээр дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- ▶ Төмөр замын дээд, автоматик телемеханик ба холбооны байгууламж угсрах
- ▶ Төмөр замын суурь бүтэц угсрах
- ▶ Төмөр замын суурь бүтэц засварлах
- ▶ Суурь бүтэц барих

Орчин үеийн дэвшилтэт технологиор ОХУ-ын Москва хот дахь “ФИРМА-ТВЕМА” компанид үйлдвэрлэгдсэн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төмөр замын суурь бүтцэд оношилгоо, хяналт, шинжилгээ хийх вагонуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

## ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЭЦ

## ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЭЦ



**“Зам төмрийн сэв шалгагч вагон ВД-УМТ-2”** нь дараах үзүүлэлтүүдэд хяналт тавих боломжтой.

- ▶ Шүргэлцэх ба үл шүргэлцэх системээр зам төмөрт хяналт тавих
- ▶ Замын гадаад байдалд өндөр нягтралшилтай камерын тусламжтайгаар хяналт тавих
- ▶ Зам төмрийн гэмтлийг илүү нарийвчлалтай, зураглал нь бүрэн, тодорхой илрүүлнэ

**“Зам оношилгооны вагон-лаборатори Декарт №1106”** нь дараах үзүүлэлтүүдэд хяналт тавих боломжтой.

- ▶ Төмөр замын техникийн байдал болон түүний үр дүнг Монгол улсад мөрдөж байгаа ЦП-515 зааврын үнэлгээний системээр автоматаар үнэлж, нэгтгэнэ
- ▶ Замын цариг, түвшинг вагоны хэмжилтийн төхөөрөмжтэй зайнаас холбогдоно
- ▶ Шүргэлцэх ба үл шүргэлцэх систем, дүрс бичлэгийн оношилгоогоор цариг, түвшин, чиг, суултыг оношилно
- ▶ Үл шүргэлцэх системээр өндөр хурдтайгаар замын үндсэн геометр хэмжээснүүдээр оношилгоо хийнэ





## Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төсөл

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь Тавантолгой уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл 233.6 км үргэлжилнэ. Төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа 1 дүгээр зэрэглэлийн, уулзваргүй, хүнд даацын, жилд 30 сая.тн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай төмөр замыг бүтээн байгуулж, дохиолол холбоо, хориглолын систем, зам төмрийг уулзваргүй болгох гагнуурын технологи, хөдлөх бүрэлдэхүүн зэрэг төмөр замын бүтээн байгуулалтын чиглэл бүрд шинэ технологи, инновацыг нэвтрүүлснээрээ онцлог юм. Тус төмөр замын тээвэрлэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр эхлүүлж, 2023 оны 05 дугаар сард төслийн суурь бүтцийг байнгын ашиглалтад оруулсан.

## Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох 21.9 км төмөр замын төсөл

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замтай 21.9 км төмөр замыг холбосон. Ингэснээр Гашуунсухайт боомт Монгол Улсын төмөр замын нэгдсэн сүлжээнд холбогдож, ОХУ болон БНХАУ руу төмөр замаар тээвэрлэлт хийх боломж бүрдсэн төдийгүй Монгол улс, БНХАУ-ын хооронд төмөр замын хоёрдох гарцыг нээсэн юм.



# ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛҮҮД

## Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төсөл

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт байрлах бөгөөд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг БНХАУ-ын Ганцмод-Ваншүйчюань чиглэлийн төмөр замтай холбох төмөр замын төсөл юм. Төслийн хүрээнд (1) хил дамнасан өргөн болон стандарт царигийн томоохон гүүрэн байгууламж (2) стандарт царигийн өртөөг нэмэлтээр байгуулахаас гадна хил, гаалийн хяналтын талбай зэрэг инженерийн цогц байгууламжийг бий болгоно. Уг төсөл нь хэрэгжсэнээр Монгол Улс БНХАУ-тай төмөр замаар холбогдох хоёр дахь гарц бий болох юм.



## Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв төсөл (ТНАЛТ)

“Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв” төсөл нь Баруун болон Зүүн Цанхийн уурхайгаас 1000 мм-ийн ширхэглэлтэй зөөвөрлөгдөж ирсэн нүүрсийг хүлээн авч, булт бутлуураар бутлан, 300 мм-ээс ихгүй хэмжээтэй болгон хольж вагонд ачих бүрэн автомат, цогц бүтээн байгуулалт юм. Уг төсөл ашиглалтад орсноор 135 ажлын байр шинээр бий болж, жилд 20 сая тонн нүүрс дамжуулан ачих хүчин чадалтай.

Энэхүү вагон, чингэлэгт нүүрс ачих байгууламж нь Монгол улсад анх удаа хийгдэж байгаа төсөл бөгөөд галт тэргийг хөдөлгөөн дунд нь зогсолтгүй ачих автомат ажиллагаатайгаар онцлог бөгөөд давуу талтай юм.

## Гашуунсухайт-Шилжүүлэн ачих терминал төсөл (ШАТ)

Гашуунсухайт Шилжүүлэн ачих терминал нь Тавантолгойн бүлэг ордоос төмөр замаар тээвэрлэсэн чингэлэгтэй ачааг, мөн Гашуунсухайт боомтоос Тавантолгой, Цогтцэций өртөөг чиглэсэн техник, тоног төхөөрөмж гэх мэт ачааг вагоноос автомашинд, вагоноос вагонд, автомашинаас вагонд шилжүүлэн ачих, бэхлэх, талбайд хадгалах, экспортын тээвэртэй холбоотой бичиг баримтын бүрдүүлэлт, төлбөр тооцоог хийх нэг цэгийн үйлчилгээ бүхий 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаатай байгууламж юм. Терминалын талбай нь бүхэлдээ гаалийн хяналтын бүс байх ба 167 ажлын байр шинээр бий болж, бүрэн ашиглалтад орсноор жилд 24.9 сая.тн ачааг шилжүүлэн ачих хүчин чадалтай.





Манай компани нь захиалагчийн хяналтын хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдэд барилга угсралтын ажлын гэрээний хэрэгжилтэд мэргэжлийн инженерүүдээс бүрдсэн багаар төмөр зам, барилга байгууламжтай холбогдолтой зураг төсөл төсөвлөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх түүний хэрэгжилтэд чанарын болон захиалагчийн хяналтыг тавин ажиллаж байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч инженер, техникийн ажилтнууд нь тухайн чиглэлээр олон улсын түвшинд мэргэшсэн туршлагатай. Хэмжилтийн багаж тоног төхөөрөмж болон мэргэжлийн программ хангамж, тусгай зөвшөөрөлтэй. Авто замын болон төмөр замын доод бүтцийн хөрсний шинжилгээ, чулууны шинжилгээ, цементийн шинжилгээ, цементээр бэхжүүлсэн суурийн шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэх, иж бүрэн багаж тоног төхөөрөмжтэй хээрийн лабораторитой. Үйл ажиллагаандаа нарийн мэргэжлийн программуудыг ашиглаж, тоо хэмжээ болон барилга угсралтын үе шатанд хяналт тавин ажилладаг.

## Бид дараах үйл ажиллагааг явуулж байна.

- ▶ Төмөр замын доод, дээд бүтцийн зураг төсөлд техникийн бичиг баримт бэлтгэхэд хяналт тавих
- ▶ Төслийн барилгын ажил гүйцэтгэх “Мастер төлөвлөгөө”-ний биелэлтийг хянах
- ▶ Явц дундын төлбөрийн хүсэлтийг хянан, шалган баталгаажуулах
- ▶ Гүүр, хоолой, ус зайлуулах суваг шуудуу түүний зураг төсөл, гүйцэтгэлд хяналт тавих
- ▶ Төмөр замын доод, дээд бүтэц барилга байгууламжийн угсралтын ажилд чанарын болон захиалагчийн хяналтыг тавих
- ▶ Төсөл дээр баригдаж буй инженерийн байгууламжийн геодезийн хяналт тавих

## Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн төслүүд:

- ▶ “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр зам”
- ▶ “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км цогцолбор төмөр зам”
- ▶ “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян холболтын 21.9 км төмөр зам”
- ▶ “Гашуунсухайт Шилжүүлэн ачих терминал”
- ▶ “Тавантолгойн нүүрс ачих логистик төв”

## ТӨМӨР ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ



Манай компани Монгол Улсад шинээр төлөвлөгдөж буй төмөр замын төслүүдийн зорилго, зорилт, тавигдсан шаардлага, стандартын дагуу төмөр замын хайгуул, зураг төсөл боловсруулах, зураг зүйн нэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

- ▶ Хайгуул, хэмжилт, судалгааны ажил
- ▶ Техникийн зураг төсөл, ТЭЗҮ
- ▶ Ажлын зураг төсөл (инженерийн нарийвчилсан зураг төсөл)
- ▶ Ашиглалтад байгаа суурь бүтцийн тээх нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар хөгжүүлэх
- ▶ Шинээр баригдах суурь бүтцийг орчин үеийн төмөр замын техник, технологийн дэвшилд тулгуурлан бүс нутгийн онцлог, хэтийн төлөвт тулгуурлан зураг төсөл
- ▶ Төмөр замын дээд бүтцийн ажлын зурагт, магадлал дүн шинжилгээ хийх, их засвар, төлөвлөгөөт засварын ажлын технологи
- ▶ Төмөр замын өртөө, зөрлөг, төлөвлөлтийн зураг төсөл
- ▶ Төмөр замын ус өнгөрүүлэх хиймэл байгууламж, терминал, ачилтын талбайн барилга байгууламжийн зураг төсөл
- ▶ Хуучин замын тээх нэвтрүүлэх чадварын өсөлттэй холбоотой өргөтгөлийн зураг төсөл
- ▶ Авто болон төмөр замын жижиг, дунд, том масштабын байр зүйн тоон зураглал

### Төмөр замын зураг төслийн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- ▶ Тавантолгой – Гашуунсухайт, Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох Холболтын төмөр замын “Техник эдийн засгийн үндэслэл” боловсруулах зураг төсөл
- ▶ Гашуунсухайт өртөөний Шилжүүлэн ачих терминалын “Техник эдийн засгийн үндэслэл” боловсруулах зураг төсөл
- ▶ Тавантолгой өртөөний тойрог замын урд Түр ачилтын талбайн зураг төсөл
- ▶ Хил холболтын төмөр замын судалгааны зураг төсөл, суурь судалгаа



## ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

---

- ▶ Манай компани 2018 онд үүсэн байгуулагдсанаас хойш Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын төмөр замын чиглэлийн компаниудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, хүний нөөцийг чадавхжуулах, зүтгүүр вагоны сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ, томоохон төслүүдийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зэрэгт хамтран ажилласаар байна.
- ▶ Оросын Холбооны Улсын Москва хотын Тиквины вагоны үйлдвэр, “ТВЕМА” ХХК, “ЭНЕРГОС” групп компаниудын үйлдвэрлэсэн вагон зүтгүүр, сэлбэг хэрэгсэл, тээвэрлэлт, ашиглалтын хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.
- ▶ Америкийн Нэгдсэн Улсын “National Rail equipment” компанийн үйлдвэрлэсэн 2GS16C серийн илчит тэрэг, “Progress Rail Locomotive” компанийн SD70ACe/LW серийн гол замын 16 зүтгүүрийг хүлээн авах ажлын хүрээнд Санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна.
- ▶ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор Хятадын талын “Чайна Энержи Интернэйшнл” ХХК, “Чайна энержи Баошөн төмөр зам” ХХК компаниудтай Санамж бичиг байгуулан өнөөг хүртэл хамтран ажиллаж байна.



QR кодыг уншуулж  
дэлгэрэнгүй мэдээлэл  
авна уу.

📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
13-р хороолол 14230, Нарны зам-62  
Юнион бюлдинг В блок 11 давхар  
☎ 976 77777727  
✉ ttrailway@ttz.mn  
🌐 www.ttz.mn



**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК**